# БНМАУ-ын эм бэлтгэлийн газар байгуулагдсан түүхийг судалсан нь

*А.Ган-Эрдэнэ[1], Г.Золжаргалан[1], Д.Авирмэд[1]*

*[1]Анагаахын шинжлэх ухааны үндэсний их сургууль*
*Email: Gan-Erdene@mnums.edu.mn, Утас:88178507*

**Түлхүүр үг.**

Эмийн худалдаа
Дотоод яам
Эмийн сан
Эмийн агуулах

**Товч утга:** 1921 оны хувьсгалаас өмнө Нийслэл Хүрээнд хэд хэдэн газар эмийн сан ажиллаж байсан тухай мэдээ байдаг. Бүх цэргийн зөвлөлөөс 1923 онд Цэргийн яамны дэргэд “Аптек хэмээх эмийн худалдааны газар”-ыг байгуулжээ. Уг эмийн сан нь цэргийн эмнэлгийн хэрэгцээг хангах зорилгоор байгуулсан боловч иргэдэд илүү үйлчлэх шаардлагатай болсон байна. Үүнээс үүдэн 1925 онд тус эмийн санг Ардын эрүүлийг хамгаалах газарт шилжүүлж нэрийг “Эм найруулах, худалдах газар” болгон өөрчилжээ. 1929 оноос хөдөө орон нутагт эмнэлгийн олон салбар байгуулж, тэдгээрийн эмийн хэрэгцээг хангах шаардлагаас үүдэн Эм найруулах, худалдах газрыг “Эмийн худалдааны ерөнхий газар” болгов. 1929 оноос Монголын төрийн удирдлагад зүүний чиглэлийг баримтлагчид гарч ирснээр улс орны хөгжлийн үзэл баримтлал, үйл ажиллагаанд зарчмын шинжтэй өөрчлөлт гарч хуучин төвөд ёсны эмнэлгийг боловсон бус, шашны суртлын нэг хэсэг хэмээн үйл ажиллагааг нь зогсоож, хот хөдөөгийн эмнэлгүүдийг европын ёсны эм, эмнэлгийн бараа бүтээгдэхүүнээр хангах, төвлөрсөн газар байгуулах ажлыг эрчимжүүлэн 1930 онд эмийн агуулахыг төв эмийн сангаас тусгаарлаж Улсын эм агуулах газрыг байгуулсан нь Монгол улсын эм хангах, нийлүүлэх газрын үндэс суурь болжээ.

**Үндэслэл:** Бүгд найрамдах Монгол ард улсын “Эрүүлийг хамгаалах байгууллага” байгуулагдсаны 55 жилийн ойн өгүүллийн эмхэтгэлд 1925-1977 оны хоорондох эм хангамжийн салбарт баримталсан бодлого, хэрэгжилтийн тухай судалсан байна. Судлаач Л.Энхбаатар “Доктор Шастин” зохиолдоо эм хангамжийн салбарын 1940-өөд оныг хүртэлх түүхийг архивын баримт материал дээр тулгуурлан дүгнэжээ. Эдгээр зохиолоос гадна “БНМАУ-ын Эрүүлийг хамгаалахын 40 жил”, “БНМАУ-ын эм хангамж 60 жилд”, “Монгол улсад эм хангамжийн алба үүсч хөгжсөний 80 жилд”, “Он цагийн түрлэг буюу эм хангамжийнхан” зэрэг ойн хурлууд, дуртгал дурсамжийн ном зохиолуудад судлаачид эм хангамжийн албаны түүхийг товчоолон дүгнэсэн байна.

**Зорилго:** Эрүүлийг хамгаалах газрын харьяа Улсын эм бэлтгэлийн газрыг үүсгэн байгуулсан үйл явцыг тодруулах

**Арга зүй:** Бид энэхүү судалгаанд чанарын судалгааны аргуудаас ашиглав. Судалгаанд, Үндэсний төв архивт хадгалагдаж байгаа Дотоод яам, Эрүүлийг хамгаалах яамны нэгжид хамаарагдаж буй эх материалыг шүүн үзэж, Эм найруулах, худалдах газрын түүхэнд холбогдох материалыг монгол бичгээс хөрвүүлж шивсний дараа харьцуулах, агуулгыг задлан шинжлэх, түүхчлэх аргуудыг ашиглан боловсруулав.

**Үр дүн:** БНМАУ-ын эм хангамжийн байгууллага байгуулагдсан үйл явцыг тодруулахдаа тус салбар байгуулагдах болсон шалтгаан, үйл явц болон эм хангамжийн салбар өргөжин тэлэхэд нөлөөлсөн хүчин зүйл гэсэн үндсэн хоёр агуулгад анхаарлаа хандуулав. Ардын хувьсгалаас өмнө Нийслэл Хүрээнд хэд хэдэн газар эмийн сан ажиллаж байсан ч 1921 оны хувьсгалын үеэр ихэнх нь хаагдаж ажиллахаа больсон байна. Бүх цэргийн зөвлөлийн 1923 оны 12 сарын 5-ны өдрийн шийдвэрээр Цэргийн яамны дэргэд Аптек хэмээх эмийн худалдааны газар нэртэй эмийн сан байгуулжээ.

Уг эмийн сан нь цэргийн эмнэлгийн хэрэгцээг хангах зорилготой байсан ч иргэдэд үйлчлэх шаардлага гарч байсан учир тус эмийн санг 1925 оны 7 сард “Ардын эрүүлийг хамгаалах газар” байгуулагдахад шилжүүлэн өгчээ. Цэргийн яамны эмийн сан нь зөвхөн европын эм худалдах газар байв. Эрүүлийг хамгаалах газарт шилжүүлэн авсны дараа төвөд эм найруулах, худалдах газрыг нэмэн байгуулж, нэрийг нь “Эм найруулах, худалдах газар” болгон өөрчилсөн байна.

1926 онд БНМАУ-ын “Эм найруулах ба худалдах газар”-ын тухай 24 зүйл бүхий дүрэм боловсруулан батлагдсан байна. Тус газрын дүрмээр эм тариа болон эмнэлгийн элдэв хэрэглэлийг худалдах эрхийг Эмийн худалдааны газарт олгож, хувь хүмүүс эм болон эмнэлгийн хэрэгсэл худалдах, хадгалахыг хориглосон байна. Мөн эмчийн хуудасгүйгээр энгийн хүмүүст эм олгохыг хориглосон бөгөөд аливаа эм худалдах, гадаад улсаас иргэд, албан газруудад ирсэн эм болон эмнэлгийн хэрэглэлийг эмийн худалдааны газраас зөвшөөрөл авч хэрэглэж байхыг онцлон заажээ. Улаанбаатар хотын амбулаторийн газруудаас иргэдэд олгох эмийг эм найруулах, худалдах газраас авч байсныг 1929 онд өөрчилж амбулаторын газраас зохих эмийг шууд олгох болсон байна.[1]

Эм найруулах, худалдах газрын дүрэм ёсоор улсын эм найруулах ба худалдах газраас улсын хязгаар дотор салбар хороодыг байгуулах, эм найруулах хэрэгт боловсорсон хүнийг томилон суулгах, тус газрын байр сууцыг засгийн газраас үнэ төлбөргүй шилжүүлэн өгч, ажиллах хүмүүсийн орон тоог тус газрын даргаас дотоод яамнаа өргөн батлуулахаар заажээ. Эм найруулах ба худалдах газрын үйл ажиллагааг Эрүүлийг хамгаалах газраас хянан шалгах бөгөөд аж ахуйн явдал нь Улсын хянан байцаах газарт харьяалагдаж, албан хаагчдын цалин хэрэглэлийг Дотоод яамнаас тогтоож байхаар болсон байна.

1929 оноос Эрүүлийг хамгаалах газрын харьяанд хөдөө орон нутагт эмнэлгийн олон салбар байгуулж тэдгээрийн эмийн хэрэгцээх хангах шаардлагаас үүдэн Эм найруулах, худалдах газрын нэрийг “Эмийн худалдааны ерөнхий газар” болгожээ.

Хот хөдөөгийн эмнэлгүүд болон иргэдийг эм, эмнэлгийн бараа бүтээгдэхүүнээр хангах төвлөрсөн газар байгуулах шаардлагын үүднээс 1930 онд эмийн агуулахыг төв эмийн сангаас тусгаарлаж, улсын эм агуулах газрыг байгуулсан байна. Мөн удалгүй эмийн худалдааг өргөтгөж, ариун цэврийн бараа, рашаан ус, айраг худалдах болж, лаборатори байгуулснаар тус газрын нэрийг “Улсын эм бэлтгэлийн газар” болгон өөрчилжээ. Ингээд тус газарт төв эмийн сан, эмийн агуулах, лаборатори, ариун цэврийн дэлгүүр, квасны завод, хөдөө орон нутгийн эмийн сан зэрэг газруудыг харьяалуулсан байна. Улсын эм бэлтгэлийн газар нь Улаанбаатар, орон нутаг дахь бүхий л эмийн худалдааг зохицуулах үүрэгтэй, ЭХЯ-нд харьяалагддаг байгууллага болжээ.[2]

Улс орны гадаад, дотоод нөхцөл байдлаас үүдэн 1929 оноос улс орны хөгжлийн үзэл баримтлал, үйл ажиллагаанд зарчмын шинжтэй өөрчлөлт гарч ЗСБНХУ, Коминтерний шийдвэрийг үг дуугүй биелүүлэгчид төрийн удирдлагад гарчээ.[3] Коминтерний бодлого 1930 онд хуралдсан МАХН-ын наймдугаар хурлын шийдвэрт тусгалаа олж, практикт хэрэгжих үндэс болов.[4] Улс оронд гарсан энэхүү зүүнтний эргэлттэй холбоотойгоор Ардын эрүүлийг хамгаалахын салбарт баримталсан бодлогод зарчмын шинжтэй өөрчлөлт гарсан байна.

1930 оны 2 сард хуралдсан МАХН-ын наймдугаар хурлаас төвөд эмнэлгийн газруудыг татан буулгаж европын боловсон ёсны эмнэлгийг өргөтгөн явуулбал зохино[5] хэмээн заажээ. Энэхүү шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд 1930 оноос төвөд эмнэлгийн төсвийг бүрэн хасч хөдөө газар амбулатори олноор байгуулж бага эмч нарыг үлэмж нэмэгдүүлэх хэрэгтэй хэмээн тогтоожээ.[6]

Ардын эрүүлийг хамгаалах яамнаас орон нутаг дахь эмнэлгийн салбарыг нэмэн байгуулах, үндэсний боловсон хүчин бэлтгэх, халдварт өвчнийг багасгах, урьдчилан сэргийлэх, эх нялхасыг хамгаалах, эм бэлтгэл, эм хангамж, рашаан сувилал зэрэг салбарыг өргөжүүлэхэд анхааран ажиллаж эхэлсэн байна.[7] Нам төрийн бодлогыг хэрэгжүүлэх ажлын хүрээнд 1931 онд нийт 25 эмнэлгийн газрыг шинээр нээв. Иргэдийг хэвтүүлэн эмчлэх газрыг 1931 онд 16 болгож өмнөх жилийнхээс 60 хувиар нэмж, орны тоог 372 байсныг 683 болгон бараг хоёр дахин нэмжээ.[8] Эх нялхасыг хамгаалах гурван газар үйл ажиллагаа явуулж байсныг 1931 оны 8 сард багтаан 33 болгон нэмж байгуулав.[9] Эмнэлгийн газрууд хэд дахин нэмэгдсэнтэй холбоотой тэдгээрт хэрэглэгдэх эм, эмнэлгийн хэрэгсэл, хадгалах агуулах сав хүрэлцэхгүй, төсөв мөнгөний хомс байдлаас шалтгаалан эм бэлтгэлийн салбарт олон хүндрэл учирчээ.

1930 онд Улаанбаатар хотод байсан аптекийн бүх бараа бүтээгдэхүүн, эд хогшлыг нэгтгэн Улсын эм агуулах газрыг байгуулсан байна. Улсын эм агуулах газар нь худалдагч 2, ажилчин 1, сав угаагч 1, лабораторийн эрхлэгч 1, эм агуулах хүн 3 нийт 8 хүний орон тоотой ажиллаж байв.[10] Удалгүй улсын эмийн агуулах газрыг “Улсын эм бэлтгэлийн газар” болгожээ. 1942 оны ЭХЯ-ны дүрмийн наймдугаар зүйлд Улсын эм бэлтгэлийн газраар дамжуулан аптекуудын хэргийг удирдана. Ард нийтэд эмийг олгох тухайн журмыг батлан гаргах ба эмийг зарцуулж буйг хянан шалгаж байна хэмээн Улсын эм бэлтгэлийн газрын эрх хэмжээг тодорхойлсон байдаг.[11]

1930 оны 6 сараас Улаанбаатар хотноо ариун цэврийн дэлгүүр нээн ажиллуулж, ард олны хэрэглэх зарим зүйлийг худалдах болсон байна. Улаанбаатар хотын больницын газруудад бага эмийн сан байгуулж, өвчтөнд эмийг саадгүй олгох явдалд ахиц гарсан байна. Улаанбаатар, Алтанбулаг хотуудад буй аптекаас гадна Баянтүмэн, Цэцэрлэг, Жавхлант зэрэг газруудад 1930 онд эмийн сан байгуулжээ. Улсын эм бэлтгэлийн газрын эм ба эмнэлгийн төхөөрөмж хэрэгсэл, ариун цэврийн барааны ихэнхийг ЗХУ-аас авчирч байв.[12] Улсын эм бэлтгэлийн газар нь Эрүүлийг хамгаалах яамны харьяа салбаруудаас зарлагаа өөрөө нөхдөг цөөн газрын нэг болсон байна.

Тус газар нь 1933 оноос өөрийн эм найруулах лабораторийг хөгжүүлэхийг гол зорилгоо болгож ажиллажээ. Лабораторид дотоодын хэрэгцээний эм үйлдвэрлэх нь эмийн өртгийг бууруулах боломжийг бүрдүүлж байв. Гэвч санхүү мөнгөний гачигдлаас шалтгаалан үйл ажиллагаа нь хязгаарлагдаж байжээ. Улсын эм бэлтгэлийн газарт 1933 оноос бараа эргэлтийн хэмжээ нэмэгдсэнтэй холбоотой бүртгэл тооцоог сайжруулах үүднээс орон тооны нягтлан бодох мэргэжилтэнтэй болсон байна.[13] Эрүүлийг хамгаалах яам 1930 оноос эмнэлгийн бага мэргэжилтнүүдийг дотооддоо бэлтгэх, ажлын байранд дагалдан

ажиллуулж, дадлагажуулах замаар боловсон хүчний хомсдлоос гарах бодлого барин ажиллаж байв. Энэ ажлын хүрээнд Эмийн санч бэлтгэх ажлыг Эмнэлгийн техникумын сургуулийн шийдвэрээр 1933 онд 10 сурагчдыг аптекийн ажилд мэргэжүүлэн сургажээ.[14]

**Дүгнэлт:** Цэргийн яамны дэргэд байгуулсан аптек хэмээх эмийн худалдааны газрыг Ардын эрүүлийг хамгаалах ерөнхий газарт шилжүүлэн өгснөөр төвөд эм найруулах, худалдах явдлыг үүсгэжээ. Улмаар анхны дүрмийг баталж, үйл ажиллагааг эрчимжүүлсэн нь Монголд эм хангах нийлүүлэх байгууллагын суурийг тавьжээ. 1929 онд эрүүл хамгаалах салбарт зүүнтний төрийн эргэлттэй холбоотой зарчмын өөрчлөлтүүд гарсан нь эмнэлгийн тоо эрс нэмэгдэх, улмаар түүнийг дагаад эм, эмнэлгийн багаж төхөөрөмжийн хэрэгцээ өсөх нөхцлийг бүрдүүлж улсын эм бэлтгэлийн газрын хөгжилд зохих нөлөө үзүүлсэн байна.

**Ном зүй:**


1. *Бүгд найрамдах Монгол ард улсын Улаанбаатар хот бүхий улсын эм найруулах, худалдах газрын тухай дүрэм. Үндэсний төв архив. Дотоод яамны данс. Ф-4, Д-1, ХН-692. х. 27*
2. *ЭХЯ-ны дүрэм. ҮТА. ЭХЯ-ны данс. Ф-22, Д-1, ХН-120. хуудас 86*
3. *Монгол улсын түүх. Тавдугаар боть. Улаанбаатар: Адмон принтинг; 2003. х.169*
4. *Монгол улсын түүх. Тавдугаар боть. Улаанбаатар: Адмон принтинг; 2003. х. 170*
5. *Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. II боть. Хянасан М.Ринчин. Улаанбаатар; 2004. т.112*
6. *МАХН-ын их, бага, Төв Хорооны хурлуудын тогтоол шийдвэр. 1921-1956 он. Улаанбаатар: УХГ; 1956. х. 296*
7. *Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. II боть. Хянасан М.Ринчин. Улаанбаатар; 2004. х.112*
8. *ЭХЯ-ны данс. Үндэсний төв архив. Ф-22, Д-1, ХН-23. х.5*
9. *ЭХЯ-ны данс. Үндэсний төв архив. Ф-22, Д-1, ХН-23. х.7*
10. *ЭХЯ-ны данс. Үндэсний төв архив. Ф-22, Д-1, ХН-23. х. 10*
11. *ЭХЯ-ны дүрэм. Үндэсний төв архив. Ф-22, Д-1, ХН-120. х.83-87*
12. *ЭХЯ-ны данс. Үндэсний төв архив. Ф-22, Д-1. ХН-23. х. 11*
13. *ЭХЯ-ны 23 оны төлөвлөгөө. Үндэсний төв архив. Ф-22, Д-1, ХН-18. х. 96*
14. *ЭХЯ-ны 23 оны төлөвлөгөө. Үндэсний төв архив. Ф-22, Д-1, ХН-18. х.100*


# Retrospecting to history of the Mongolian Pharmacy


*Gan-Erdene A[1], Zoljargalan G[1], Avirmed D[1]*

*[1]MNUMS*
*Gan-Erdene@mnums.edu.mn, Tel:88178507*



There are some facts about the operation of several pharmacies in Niislel Khuree. In 1923, the Military Council set up pharmacies by renewing “medication sales centers – APTEK”. At first, the pharmacy has directed its activities to meet the needs of military hospitals. Nevertheless, it was necessary to serve the public more than military. Due to growing public needs, the pharmacy was transferred to the "People’s Health Protection Department" in 1925.In 1929, branches of health centers were established in the countryside, therefore, it was necessary to supply medications to those centers. Because of this situation, the name of “Sales and Compound Medicine Department” was changed to “General Sales Department of Medicine”.

Starting from 1929, Mongolian development agenda has conceptually changed when the government has dominated by the supporters of left-wing politics. This change has significantly affected the policy and practices of the "People’s Health Protection Department". Tibetan hospital and medical means were prohibited because it was considered as religious and outdated, therefore, operation of such hospitals were cancelled. The State medicine storage was established in 1930 to supply medicines and medical resources to the hospitals and patients in the countryside as well as cities.

In conclusion, the first medicine sales department established based on the needs of military and general public has expanded due to external and internal factors and eventually the department became the Medicine Compound Department of the People’s Republic of Mongolia. The State Department of Medical Supply was rooted on this development process and it has been strengthened since then.